

“Япон дууг хэн сайн дуулах вэ?” тэмцээн
Оролцогчдод зориулсан танилцуулга

Тэмцээний ерөнхий танилцуулга

- Зохион байгуулагдах газар: Монголын хүүхдийн ордон
- Эхлэх цаг: 14 цаг
- Цуглах цаг: 13:45 цаг
- Тайзны ард бэлэн байх цаг:

13:45 цагаас No.1~No.8

14:40 цагаас No.9~No.16

15:00 цагаас No.17~No.23

※Цуглах цагийг ойролцоогоор тооцсон байгаа бөгөөд тайзан дээр гарахаас өмнө бүгд заасан суудалд сууж хүлээхийг анхаарна уу.

Шалгаруулах арга, үзүүлэлт

- Шүүгчдийн бүрэлдэхүүн: Японы ЭСЯ, Япончуудын холбоо, Нийслэлийн боловсролын газар, Монголын хүүхдийн ордон
- Дөрвөн шүүгчийн үнэлгээний нийлбэрээр шалгаруулна
- Шалгуур үзүүлэлт: дууны чанга сул, хөг өнгө, илэрхийлэмж, япон хэлний дуудлага

Шагнал

- 1~3 байр: JENESYS2016 хөтөлбөрт оролцох эрх. Гэвч дараах тохиолдолд хамаарахгүй:
 - 6 сар ба түүнээс дээш хугацаагаар тасралтгүй Японд амьдарч байсан хүн
 - Өнгөрсөн 3 жилийн хугацаанд 7 ба түүнээс дээш хоногийн хугацаагаар Японд зорчсон хүн
 - Японы Засгийн газрын урилгаар Япон явж байсан хүн

Санамж

- Дуугаа солих боломжгүй.
- Дууны эх үүсвэр: CD-нээс амьд хөгжимтэй дуулахаар болсон бол түүнийгээ 28-ны өдөр хүртэл мэдэгдсэн байх.
- Тэмцээн яг цагтаа эхлэх бөгөөд бүх үйл ажиллагаа “япон цаг”-аар явагдана.
- Урьдчилан мэдэгдэлгүйгээр цагтаа цуглаагүй тохиолдолд тухайн оролцогчийн тэмцээнд орох эрхийг хасна.
- Шагнал гардуулах ёслолын үеэр өөрийн биеэр байгаагүй тохиолдолд шагнал авах эрхгүй болох тул заавал хаалтын ажиллагааг дуустал байх. Зайлшгүй шаардлагаар эрт харих болсон тохиолдолд заавал шүүгчийн суудалд ойр байгаа тэмцээний зохион байгуулагчид мэдэгдэх.
- Дуучны ар талд бүжиглэх бүжигчдийн тоо өөрчлөгдөж болох боловч хамгийн ихдээ 8 хүртэл бүжигчид байх.
- Сургууль хамт олноороо оролцогчоо хөгжөөн дэмжихээр ирвэл сайн.